



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 619

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2015 оны 2015/207 дугаар акт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.3, 4.4 заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Цэвэр агаарын сангийн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон нийт 594,909,000.00 (таван зуун ерэн дөрвөн сая есөн зуун есөн мянган) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан шингэрүүлсэн хийн түлш хадгалах, нөөцлөх цэнэглэх 100 м³ эзлэхүүн бүхий 6 (зургаан) ширхэг нөөцийн савыг тус яамны үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэлд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001170

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн
619 ... дугаар тогтоолын хавсралт

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үндсэн хөрөнгөд
бүртгэх хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)
1	Нөөцийн сав	2015	ш	2	85,000,000.00	170,000,000.00
2	Нөөцийн сав	2015	ш	2	87,454,500.00	174,909,000.00
3	Нөөцийн сав	2015	ш	2	125,000,000.00	250,000,000.00
	Нийт дүн			6	297,454,500.00	594,909,000.00
						(таван зуун ерэн дөрвөн сая есөн зуун есөн мянган)